



## БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН АШИГЛАЛТЫН АЛБАНЫ АЖИЛТNUУДЫН ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ХУВЦАСНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Тус албаны ажилтнуудын өвөл, зуны ажлын гутал, хувцас болон "Хөдөлмөр хамгааллын хувцас"-д тавигдах шаардлага, хувцасны загварыг тодорхойлсон болно.

### 2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

2.1. Хөдөлмөр хамгааллын хувцас нь MNS ISO 13688:2000 "Хөдөлмөр хамгааллын хувцас- Ерөнхий шаардлага", MNS 5623:2006 "Хөлний хамгаалалт. Ажлын тусгай гутал", ISO 20345:2011 "Ажлын хамгаалалттай гутал", EN 342:2017 "Хүйтэн нөхцөлд өмсөх ажлын хувцас" стандартуудад дүйцэхүйц шаардлагыг бүрэн хангасан байна.

2.2. Ажлын тусгай хувцас нь техникийн үзүүлэлт хэсэгт тусгасан шаардлагыг бүрэн хангасан байх шаардлагатай бөгөөд дараах баримт бичгийг хавсарган ирүүлнэ. Үүнд:

2.2.1. Үйлдвэрлэлийн гарал үүслийн гэрчилгээ;

2.2.2. Баталгаат хугацааг тодорхойлсон гэрчилгээ;

2.2.3. Тендерт шалгарсан нийлүүлэгч нь нийлүүлэх бүх хувцасны загварыг үндсэн болон туслах материалын биет каталогийг эскиз зургийн хамт гэрээ хийхээс өмнө захиалагчид ирүүлнэ.

2.2.4. Тендерт шалгарсан хувцас болон үндсэн, зарим туслах материалын загварыг захиалагч авч үлдэх бөгөөд энэ нь нийлүүлэх бусад хувцсыг шалгах загвар /этalon/ болно.

### 3. ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

№	Материал	Шаардлага	Өнгө	Тайлбар
<b>1. Өвлүүлийн хүрээмж</b>				
1	Гадна өнгө	100% амьсгалах боломжтой полиестер (breathable polyester), цахилгаан дамжуулдаггүй, хүний биед сөрөг нөлөөгүй Ажлын тусгай хувцасны материал, бүрдэл хэсгүүд нь ажлын нөхцөлд хүнд саад болохгүй байх Хүний биед хүрэлцэхүйц хэсгүүд нь аливаа цочроо, шархлаа үүсэхгүй, ширүүн, хурц ирмэггүй байх	хар хөх код 000066	

		Хувцасны дизайн нь өвлийн улиралд хөдөлмөрийн нөхцөл, биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байхаас гадна хувь хүнд тохируулан хэмжээг нь өөрчилж болохуйц буюу хэмжээний өргөн сонголттой байх		
2	Дотор	Гадна доод халаасны дээгүүр хувцасны дотуур бус хийх		
3	Дотрын материал	Дулаан хадгалах чадвар сайтай, хөнгөн чанартай, зориулалтын дотрын материалаар хийгдсэн байх	Xар хөх	
4	Юудэн	Юудэн нь хүрэмнээс салдаг цахилгаантай байх		
5	Зах	Босоо захтай, хацар, хүзүү хайрахгүй материалтай байх		
6	Энгэр	Аливаа зүйлд татагдахгүй, орооцолдохгүй сайн чанарын цахилгаантай, цахилгааны дээд, доод хэсэгт 2 товч бүхий цахилгаан далдлагчтай		
7	Байгууллагын эмблем	Зүүн дээд халаасны дээр албаны эмблемийг өнгө ялган оёсон байх	эмблемийн өөрийн өнгө	
8	Халаас	Энгэрийн баруун (гадна) талд 1 ширхэг халаас байна. Гадна ил байрлах ба дээшээ босоо чиглэлтэй, халаасны дээд ам наалддаг хийцтэй байх Цээж хэсгийн баруун, зүүн (доод) талд 2 ширхэг халаас байна. Гадна ил байрлах ба дээшээ босоо чиглэлтэй, халаасны дээд ам наалддаг хийцтэй байх	Xар хөх	
9	Ханцуй	Ханцуй нь бугуй хэсэгтээ резинэн оруулагатай (гарын хуруу хүртэл бээлий маягийн)		
10	Гэрэл ойлгогч	Үрд талд: Энгэрийн баруун (дээд) халаасны дээд талаар хэвтэй чиглэлтэй халаасны хэмжээгээр 5см өргөн гэрэл ойлгогчтой байна. Ар талд: Ар талын гэрэл ойлгогчийг урд талын гэрэл ойлгогчтой ижил түвшинд байрлуулна	Мөнгөлөг саарал	

## 2. Өвлийн өмд


1	Гадна өнгө	100% амьсгалах боломжтой полиестер (breathable polyester), цахилгаан дамжуулдаггүй, хүний биед сөрөг нөлөөгүй	Xар хөх код 000066	
2	Дотрын материал	Дулаан хадгалах чадвар сайтай, хөнгөн чанартай, салдаг байх	Цэнхэр	
3	Халаас	Ташааны 2 талд ташуу чиглэлтэй Гуяны хажуу хэсэгт 2 халаас байх ба тэгш өнцөг хэлбэртэй, дээд талдаа цахилгаантай байх	Xар хөх	

		Өмдний арын хэсэгт байрлах 2 ширхэг байх		
4	Мөрөвч	Өмдний мөрөвч нь хүний биений далны доод тал хүртэл битүү өөрийн биеийн хэмжээнд тааруулахаар тохируулагчтай байх		
5	Гэрэл ойлгогч	Хөлний шилбэний хэсэгт бүтэн тойрсон 5 см өргөнтэй гэрэл ойлгогчтой байх	Мөнгөлөг саарал	

### 3.Өвлийн гутал


1	Гутлын стандарт	Ажлын тусгай гутлын ерөнхий шаардлага олон улсын стандарт		
2	Гадна тал	Сайн чанарын шир, арьсан материалтай, 30 см орчим өндөр түрийтэй, түрийний дээд хэсэгт цас, хог орохоос хамгаалсан даавуун хамгаалалттай байх	хар, бор	
3	Дотор тал	Ус чийг татахгүй, нэхий дотортой, даацаын цохилт даах чадвартай хуванцар хамгаалалттай байх		
4	Хамгаалалт	200 джоулын механик биетийн цохилтыг даах цахилгаанждаггүй, полимер хамгаалалттай		
5	Ул	Хөлд эвтэйхэн нумтай, статик цахилгаан дамжуулахгүй, хальтрахгүй, -40°C хэмд хөлдөхгүй, тос, хүчилд тэсвэртэй байх		

### 4. Зуны хүрэм

1	Үндсэн материал	65% полиестер, 35% хөвөн даавуу цахилгаан дамжуулдаггүй, хүний биед сөрөг нөлөөгүй.	Хар саарал, хар хосолсон	
2	Зах	Хүзүү холгохоргүй, зөөлөн даавуун 8-10 см өргөнтэй байх		
3	Хормой	Хүрэмний доод хэсэг монжаттай, хоёр хажуу талдаа зориулалтын резинтэй байх		
4	Халаас	Энгэрийн гадна баруун, зүүн талд 2 ширхэг халаас байна. Гадна ил байрлах ба дээшээ босоо чиглэлтэй, халаас нь ташуу чиглэлтэй өнгө ялгасан /улбар шар/ цахилгаантай байх		
		Цээж хэсгийн (доод) баруун, зүүн талд 2 ширхэг халаас байна. Дотор байрлалтай ташуу чиглэлтэй, халаасны амыг дарсан цахилгаантай байх		
5	Агаар сэлгэгч	Ар талын дал, нурууны дээд босоо хэсэгт агаар чөлөөтэй сэлгэж байхаар торон даавуугаар суналттай оруулга оёсон байх		
6	Гэрэл ойлгогч	Урд талд: Энгэрийн хоёр халаасны дээд талд мөр дагасан, ар талд хөндлөн гэрэл ойлгогчтой байна	Мөнгөлөг саарал	
7	Ханцуй	Ханцуйн монжат нь ихэсгэж богиносгох зориулалтын зангуутай		

		байх. Зүүн талын ханцууйнд жижиг халаастай байх		
8	Байгууллагын эмблем	Зүүн дээд халаасны дээр албаны эмблемийг өнгө ялган оёсон байх	эмблемийн өөрийн өнгө	
9	Нэмэлт	Мөрний 2 хажуу хэсэгт үндсэн өнгөнд зохицсон оруулгатай байх		
10	Нэмэлт	Энгэрийн халаасны дунд босоогоор, дээд хэсэгт хөндлөнгөөр, энгэрийн товч далдлагчийг босоогоор, халаасны дээд хэсэгт хөндлөнгөөр улбар шар өнгөөр давхарласан оруулгатай байх	улбар шар	

#### 5. Зуны өмд

1	Үндсэн материал	65% полиестер, 35%, хөвөн даавуу цахилгаан дамжуулдаггүй, хүний биед сөрөг нөлөөгүй	Харсаарал, хархосолсон	
2	Халаас	Өмдний баруун, зүүн талд 2 ширхэг, ташуу чиглэлтэй, цахилгаантай халаас байх		
3	Нэмэлт	Өвдөгний болон егзөгний хэсгээр өөрийн өнгөөр давхарласан оруулгатай байх		
4	Нэмэлт материал	Өвдөгнөөс дээш саарал, өвдөгнөөс доош хар өнгөтэй байх		
5	Оруулга	Халаасны ташуу амсар дагуу улбар шар өнгөөр давхарласан оруулгатай байх		
6	Гэрэл ойлгогч	Өмдний доод шуумагнаас дээш 30 см хэсэгт бүтэн тойрсон гэрэл ойлгогчтой байх	Мөнгөлөг саарал	

#### 6. Зуны гутал

1	Гутлын стандарт	Ажлын тусгай гутлын ерөнхий шаардлага олон улсын стандарт	Хар, хүрэн	
2	Гутлын гадар	Ус нэвчдэггүй бүрэн боловсруулсан 2,1 мм ийн зузаантай цэвэр ширэн материалтай байх		
3	Гутлын хамгаалалт	1. 200 джоулын механик үйлчлэлээс хамгаалах, хөнгөн, металл бус полимер хамгаалалттай байх 2. Хатгалтаас хамгаалсан дунд ул нь металл бус орчин үеийн технологийн, нэхмэл утастай байх 3. Өсгий болон хоншоорын сайжруулсан хамгаалалт нь элэгдлийн эсрэг хамгаалалттай байх ба шаардлагатай үед үрэлт, зусэлтийн нөлөөг бууруулдаг байх		

4	Гутлын дотор	1. Зөгийн үүр шиг бүтэцтэй 3D доторлогоотой байх ба энэ нь хөлний амьсгалах чадварыг нэмэгдүүлж, хөлсийг түргэн шингээх, хатаах зориулалттай байх. 2. Гутлын түрийн хэсэг болон хэлийг таны хөлийг тав тухтай байлгах зорилгоор зөвлөвчилсөн байх		
5	Гутлын ул	1. Элэгдэлд тэсвэртэй гулгалтын эсрэг өндөр үзүүлэлт бүхий 2D цутгамал ултай, бензин тос хүчилд тэсвэртэй байх. 2. Хатгалтаас хамгаалсан дунд ул нь металл бус орчин үеийн технологийн, нэхмэл утастай байх. Дотор ул нь цахилгаанждаггүй, хөлийн анатомийн бүтцэд нийцсэн хөлийн хөдөлгөөнийг хязгаарлахгүй, хөнгөн уян налархай байх		

#### Нийлүүлэх хувцасны тоо хэмжээ

№	Нормын болон дүрэмт хувцасны нэр	Эдэлгээний норм	Тоо ширхэг
1	Зуны хувцас	1	53
2	Зуны гутал	2	53
3	Өвлийн хувцас	4	9
4	Өвлийн гутал	4	26

#### 6. ХҮЛЭЭН АВАХ

6.1. ИНЕГ-ын даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу шалгаж, хүлээн авах актыг үйлдсэнээр хөдөлмөр хамгааллын хувцсыг хүлээн авсанд тооцно.

6.2 Баталгаат хугацаа нь ажил хүлээн авах комисс нь актад гарын үсэг зурж хүлээн авснаас хойш 6 сар.

6.3 Ачааг хүргэх цэг: Улаанбаатар хот, Буянт-Ухаа, ИНҮТ, Барилга, байгууламжийн ашиглалтын алба

**Техникийн тодорхойлолт бэлтгэсэн:**

Иргэний нисэхийн үндэсний төвийн Барилга,  
байгууламжийн ашиглалтын албаны дарга  
Үнэлгээний хорооны дарга:



Ч.Болдсүрэн

Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөдөлмөрийн  
аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийн дарга  
Үнэлгээний хорооны гишүүн:



С.Батхуяг

“Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн төв”

Төрийн бус байгууллагын гишүүн,

Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүн:



О.Баярсайхан

“ХУД Яармаг” Төрийн бус байгууллагын гишүүн,  
Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүн:



О.Бат-Амгалан

Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө  
оруулалт, захиалагчийн албаны Худалдан авах  
ажиллагааны тасгийн мэргэжилтэн,  
Үнэлгээний хорооны нарийн бичиг:



Д.Насандэлгэр